

**СОЁЛ, УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛИЙН III БАЙРНЫ
НОМЫН САНГИЙН ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2017 оны 09 сарын 08-ны өдөр

Дугаар ...

44
ТХ-07/2017

Улаанбаатар хот

Нэг талаас Соёл, урлагийн их сургууль (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “ДСЕМ Сервис” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2017 оны 09 сарын 08-ны өдөр энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь Соёл, урлагийн их сургуулийн хичээлийн III байрны номын сангийн засварын ажлыг (цаашид “ажил” гэх) 42,912,236 /дөчин хоёр сая есөн зуун арван хоёр мянга хоёр зуун гучин зургаа/ төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: 42,912,236 /дөчин хоёр сая есөн зуун арван хоёр мянга хоёр зуун гучин зургаа/ төгрөгийг Соёл, урлагийн их сургууль болон тус сургуулийн Соёлын сургуулийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Барилгын засварын ажлын зардал 42,912,236 төгрөг.

4. Гүйцэтгэгч нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороонд байршилтай СУИС-ийн хичээлийн III байрны номын сангийн засварын ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэнэ. Ажлыг 2017 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр эхэлж, 2017 оны 10 сарын 2-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг;
- 5.3. Үнийн санал;
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Санхүүжилтийн хуваарь;
- 5.9. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор урьдчилгаанд үнийн дүнгийн 30 хувь болох 12,873,671 /арван хоёр сая найман зуун далан гурван мянга зургаан зуун далан нэг/ төгрөгийг, засварын ажлын гүйцэтгэлийн 60 хувьд гүйцэтгэлийн акт үйлдэн санхүүжилтийн үнийн дүнгийн 30 хувь болох 12,873,671 /арван хоёр сая найман зуун далан гурван мянга зургаан зуун далан нэг/, гэрээнд заасан чанарын шаардлага хангасан засварын ажлыг актаар хүлээлгэн өгсний дараа үлдэгдэл төлбөр болох 40 хувь болох 17,164,894 /арван долоон сая нэг зуун жаран дөрвөн мянга найман зуун ерэн дөрөв/ төгрөгийг гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

9. Тээврийн зардал болон бусад татвар, хураамж үнийн дүнд багтсан байна.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичиг, цахим шуудан болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Соёл, урлагийн их сургуулийн
Соёлын сургуулийн захирал
..... /Г.Сүхбат/

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо, СУИС-ийн хичээлийн III байр
Дансны дугаар: Төрийн банк 102900116087

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ДСЕМ Сервис” ХХК-ийн
захирал
УЛААНБААТАР ХОТ
..... /Д.Доржсэмбэ/



Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
8 дугаар хороо
Дансны дугаар: Хаанбанк 5030260423